



# УЛААНБААТАР хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны ТОГТООЛ

19 70 оны 6-р сарын 25 ны өдөр

Дугаар - 136

Улаанбаатар хот

*ТЗ-ноо 1990 оны 140-р тогтоолоор хүчинсүй.*

**ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ.**

Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх  
Захиргаанаас **ТОГТООХ нь:**

Хот, районы АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны дэргэдэх орон  
тооны бие эдийн засгийн зөвлөлийн дүрмийг баталсугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН

ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ I-Р

ОРЛОГЧ ДАРГА

Д.ШИРНИН

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА

Д.ДАМДИНСҮРЭН

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх  
Захиргааны 1970 оны 6-р сарын 25-н  
өдрийн 136-р тогтоолоор батлав.

УЛААНБААТАР ХОТ, РАЙОНЫ АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААДЫН ДЭРГЭДЭХ ОРОН ТООНЫ БИШ  
ЭДИЙН ЗАСГИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ.

Нэг. Ерөнхий зүйл.

1. Эдийн засгийн зөвлөл нь хот, районы төсөвтэй харьцдаг үйлдвэр, аж ахуйн ба төсөвт байгууллагуудын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд нягтлан бодох бүртгэлийн, улирал, жилийн тайлан баланс, статистикийн мэдээ, үйлдвэр-санхүүгийн төлөвлөгөөний үндсэн дээр судалгаа, шалгалт хийж уул байгууллагуудын эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулах арга хэмжээг боловсруулж тэр байгууллагын эдийн засгийн ажил хариуцсан дээд байгууллага, хэлтсүүдтэй саналаа зөвшөөрөлцөн ажил зохиож арга хэмжээ авахуулах, хот районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны хуралд асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлж байх зорилготой байна.

2. Эдийн засгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хотод 9-II дүн, районд 5-7 хүнтэйгээр хот, районы АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны хурлаар батлаж ажиллуулах бөгөөд эдийн засгийн зөвлөл нь дарга, нарийн бичгийн даргатай байна.

3. Эдийн засгийн зөвлөл нь хотод АДХ-ын гүйцэтгэх захиргааны I-р орлогч дарга, районд районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргын удирдлагын дор ажиллаж ажлынхаа тайланг хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргаанд жил бүр оруулж байвал зохино.

Хоёр. Эдийн засгийн зөвлөлийн эрх үүрэг.

1. Эдийн засгийн зөвлөл нь бүтэн, хавас жилээр ажлын төлөвлөгөө зохиож зөвлөлийнхөө хурлаар батлан жилд 4-өөс доошгүй байгууллагын эдийн засгийн үзүүлэлтэд бүрэн судалгаа хийнэ.

2. Эдийн засгийн зөвлөлийн хурлаар хийсэн судалгааны үр дүн ба байгууллагуудын дарга, ерөнхий ня-бо, санхүү төлөвлөгөө, статистик, хөдөлмөр цалин хөлсний мэргэжилтэн нарын ажлын талаар илтгэл сонсголыг хэлэлцэж протоколоор зөвлөлтөөн санамж өгч байна.

3. Эдийн засгийн зөвлөлөөс хот, районы АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанд оруулж байгаа асуудал нь улсын хэмжээгээр мөрдөж байгаа хууль, дүрэм, заавар, төлөвлөлтийн үндсэн зарчмыг харгалзан үзэж бүрэн боловсрогдсон байх.

4. Эдийн засгийн зөвлөлийн гишүүд нь зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарын удирдлагын дор ажиллаж тэдний шийдвэрийг бүрэн биелүүлж байх үүрэгтэй.

5. Эдийн засгийн зөвлөл нь шаардлагатай үед байгууллагуудын зарим ажилтан нарыг дайчлан ажиллуулах эрхтэй.

Гурав. Эдийн засгийн зөвлөлтэй харилцагч  
байгууллагын үүрэг.

1. Эдийн засгийн зөвлөлтэй харилцагч байгууллагууд нь судалгаа шинжилгээний ажилд шаардагдах материалыг байр, уналга, холбогдох хүмүүсийн хамт саадгүй бэлтгэн өх ба заасан хугацаанд нь илтгэл сонсголоо оруулах, зөвлөлийн протоколоор өгөгдсөн зөвлөлтөөн санамжийг биелүүлэх үүрэгтэй.

2. Эдийн засгийн зөвлөлтэй харилцагч байгууллага нь судалгаа шинжилгээ, шалгалт, илтгэл сонсголоос үүссэн шинээр боловсруудож байгаа зүйлийн эдийн засгийн ач холбогдлыг мэдсэний үндсэн дээр холбогдох байгууллагын санал авах, дээд байгууллагад танилцуулах, хот, районы АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанд хэлэлцүүлэхээр оруулахад эдийн засгийн зөвлөлтэй хамтран ажиллах үүрэгтэй.